



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

“Олон улсын Сувилагчдын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь заалт, Сувилахуй, үйлчилгээний албаны саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын Сувилагчдын өдрийг “Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын жил”-ийн хүрээнд ажил, мэргэжлийн бүтээлийн уралдаан зохион байгуулах, сайн туршлагаа солилцох, ахмад настнуудаасаа суралцах хэлбэрээр тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Олон улсын Сувилагчдын өдрийн арга хэмжээний удирдамжийг 1 дүгээр, арга хэмжээнд шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Олон улсын Сувилагчдын өдрийн үйл ажиллагаа зохион байгуулахад шаардагдах 1.776.000 /нэг сая долоон зуун далан зургаан мянга/ төгрөгийг төсөл, хөтөлбөрийн зардлаас гаргахыг Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Х.Одгэрэл/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба /Б.Солонго/-нд үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны 4/8 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



**ОЛОН УЛСЫН СУВИЛАГЧ НАРЫН ӨДРИЙН АРГА
ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

Үндэслэл: Олон улсын сувилагч нарын нийгэмлэгээс 2022 оныг "СУВИЛАГЧ-УДИРДАХ ДУУ ХООЛОЙ СУВИЛАХУЙН САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙЖ, ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭЭ" уриан дор олон улсын сувилагч –эх баригч нарын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхээр төлөвлөсөн байна. Шинжлэх ухаанд суурилсан, сувилахуйн мэргэжлийн тусламж, үйлчилгээг шинэлэг аргаар дэмжин хөгжүүлэх нь сувилахуйн салбарын өмнө тулгамдсан асуудал байсаар байна. Цус сэлбэлт судлалын шинжлэх ухаан нь эрүүл мэндийн салбарын нэн чухал салбарын нэг бөгөөд салбарын хөгжилд технологич сувилагч нарын оролцоо тэдний шинэ санал санаачлага чухал. 2022 оныг Олон улсын Сувилагчдын өдрийг "Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал" сэдвийн хүрээнд ажил, мэргэжлийн уралдаан зохион байгуулах, сайн туршлагаа солилцох, ахмад настуудаасаа суралцах хэлбэрээр тэмдэглэн өнгөрүүлэх нь чухал юм.

Зорилго: Цус сэлбэлт судлалын салбарын технологич сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх, хамтач, эелдэг, найрсаг уур амьсгалыг бүрдүүлэх, ахмад үеэсээ суралцах багийн ажиллагааг дэмжихэд оршино.

Зорилт:

1. "МИНИЙ МЭРГЭЖИЛ-ТЕХНОЛОГИЧ СУВИЛАГЧ" бүтээлийн уралдаан зохион байгуулах
2. "Сайн туршлага- ахмад настуудаасаа суралцаж" ахмад настангууддаа хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион явуулах

Хүлээгдэж буй үр дүн:

1. Төвийн сувилахуйн тусламж үйлчилгээний шинэ санал, санаачлага нэмэгдэнэ.
2. Ахмад үеэсээ суралцаж хамтач, эелдэг, найрсаг уур амьсгал бүрдэнэ.

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	“Миний мэргэжил-технологич сувилагч” бүтээлийн уралдаан зохион байгуулна	3-р сарын 15-аас- 5-р сарын 1	СҮА-ны дарга Ж.Нармандах Сувилахуйн албаны гишүүд
2	“Сайн туршлага- ахмад настнуудаасаа суралцъя” арга хэмжээ	5 сарын 12	ЭШМТА-ны дарга Б.Солонго ажлын хэсэг
3	Улсын хэмжээний нэгдсэн арга хэмжээнд төлөөлөл оролцуулна	5 сарын 12	СҮА-ны дарга Ж.Нармандах

“Миний мэргэжил-технологич сувилагч” бүтээлийн уралдаан:

1. Технологич сувилагч, тусгай мэргэжилтний тусламж үйлчилгээнд ашиглах шинэ санал, санаачлага агуулсан байна.
2. Бүтээлийн нэр, санаачлага тайлбарыг хавсаргасан байна
3. Эмнэлгийн нэр, овог, нэр /бүтэн бичих/


Жич: Хугацаа хоцорсон бүтээлийг хүлээн авахгүй. Мөн уралдаанд ирүүлж буй бүтээлийг буцаан олгохгүй.

“Сайн туршлага- ахмад настнуудаасаа суралцъя” арга хэмжээ:

- Алба тасгийн дарга, эрхлэгч нар
- Сувилагч, тусгай мэргэжилтнүүд
- Ахмад, сувилагчд

Зохион байгуулагч: Сувилахуй, үйлчилгээний алба

ЦОСҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны 4/8 дугаар тушаалын
2 дугаар хавсралт



ОЛОН УЛСЫН СУВИЛАГЧДЫН ӨДРИЙН
ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Зардлын тайлбар	Тоо	Нэгжийн үнэ /Төгрөг/	Нийт үнэ /Төгрөг/
1.	Мөнгөн шагнал	“Миний мэргэжил технологич сувилагч”- бүтээлийн уралдааны I, II, III, тусгай байр 2ш	5	I-500.000 II-250.000 III-150.000 Тусгай байр 2- 50.000*2=100.000	1.000.000
2	Дурсгалын зүйлс	Сувилагч нарт туршлагаасаа хуваалцах арга хэмжээнд уригдсан ахмад сувилагчид өгөх гарын бэлэг	2	80.000	160.000
3	Цэцэг		2	10.000	20.000
4.	Үдийн хоол	Сайн туршлага солилцох, ахмад настуудаасаа суралцах арга хэмжээний хоол, цайны зардал	30	13.200	396.000
5.	Цайны зардал		32	6.250	200.000
	Нийт				1.776.000